



**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАРТАХЛЫН ҮЕД
ХҮҮХДИЙН ЗУСЛАН АЖИЛЛУУЛАХ ТҮР ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед ажиллах хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны чиглэл, эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаа, амрагч, байгууллага болон ажилтны хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгаллын тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цартахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Эрүүл ахуйн тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, Ерөнхий шаардлага MNS5633:2019 стандарт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан "Хөгжлийн жишиг хөтөлбөр" болон бусад хууль тогтоомжийг баримтална.

Хоёр. Зуслангийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах нэмэлт шаардлага, хүлээх үүрэг

2.1. Зуслангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, хариу арга хэмжээний талаар тодотгол хийж, бэлэн байдлыг хангана.

2.2. Үйл ажиллагаа эхлэхээс өмнө зуслангийн орчмын бүс, амралтын байруудад цэвэрлэгээ хийж, мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэсэн байна.

2.3. Зуслангийн үйл ажиллагаа явуулах явцад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эмч, эрүүл ахуйч эмчийг ажиллуулах ба багш, ажилчид, хүүхдийн эрүүл мэндэд тогтмол хяналт тавьж ажиллана.

2.4. Сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах өрөөг бэлтгэсэн байна.

2.5. Шаардлагатай үед хэрэглэх эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламжийн эм, хэрэгслийг бэлтгэсэн байна.

2.6. Сэжигтэй тохиолдол илэрсэн үед хэрэглэх иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл(комбинзон, №95 амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, бээлий, малгай зэрэг) –ийн нөөцийг бэлтгэсэн байна.

2.7. Зуслангийн үйл ажиллагаа явуулж байх хугацаанд байнгын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийхэд шаардлагатай улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай, хэрэглэх заавар нь батлагдсан халдваргүйтгэлийн бодис, шаардлагатай тохиолдолд хэрэглэх хамгаалах хувцас, хэрэгсэл, гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай бодис, шингэн саван, гарын цаасан алчуур, цэвэрлэгээний материалын нөөцийг бүрдүүлнэ.

2.8. Халдваргүйжүүлэх бодисыг тусгай зөвшөөрөл бүхий нийлүүлэгч аж ахуйн нэгжээс хэрэглэх зааврын хамт авна. Хүчинтэй хугацаа дууссан, хаяг шошгогүй бодисыг хэрэглэхгүй.

2.9. Зуслангийн удирдлага, эмч, эрүүл ахуйч, багш, ажиллагсдыг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх талаар сургалтад бүрэн хамруулсан байна.

2.10. Өрөөнд байх ор хоорондын зайг 1-1,5 метр байхаар байрлуулах ба гэр бүлийн гишүүдийг нэг өрөөнд байрлуулна.

2.11. Эрүүл мэндийн яам болон холбогдох мэргэжлийн байгууллагуудаас гаргасан халдвараас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг амралтын байрны коридор, өрөө, ариун цэврийн өрөөнд байршуулсан байна.

2.12. Зусланд халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед түр тусгаарлах өрөөг бэлтгэх ба яаралтай мэдээлэх харьяа өрх, дүүргийн Эрүүл мэндийн төв, аймаг, сумын эмнэлгийн холбоо барих утасны дугаарыг урьдчилан авч бэлтгэсэн байна.

2.13. Багш, ажилчид, амрагч хүүхдийн эрүүл мэндэд хяналт, тандалт хийх багаж, хэрэгслийг бэлтгэсэн байна.

2.14. Амрагч хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг гарган, бүртгэж, баталгаажуулсан байна./овог, нэр, гэрийн хаяг, утасны дугаар, шаардлагатай тохиолдолд холбогдох хүний утасны дугаар г.м/

2.15. Багш, ажилчид, хүүхдийн гар угаах нөхцөлийг бүрдүүлж, ариун цэврийн өрөөнд гар угаах шингэн саван, гар арчих цаасан алчуур, гар халдваргүйжүүлэх

уусмалыг хүрэлцэхүйц хэмжээгээр байршуулсан байна. Мөн амралтын байрны орох, гарах хаалганы хэсэг, хоолны газар, амрах өрөө, ариун цэврийн өрөөнд гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай уусмалыг тогтмол байршуулна.

2.16. Хүүхдийг хооллох танхимд орох, гарахдаа нэг дор олноороо бөөгнөрөхгүй байх, нэг удаа 10-аас илүүгүй хүүхдийг хооллохоор зохицуулалт хийж, зураглал гаргаж, танилцуулсан байна.

2.17. Усны эх үүсвэрт хамгаалалт тогтоон бохирдлоос сэргийлэх арга хэмжээ авч, ус нөөцлөх савыг угааж халдваргүйжүүлэн, ундны усанд хими, нян судлалын шинжилгээ хийлгүүлж дүгнэлт гаргуулна.

2.18. Бохир ус цэвэрлэх байгууламж, бохир усны цооногийг стандартын шаардлагад нийцүүлж, байгальд хаяж буй бохир усны чанарт эрх бүхий байгууллагаар шинжилгээ хийлгэж дотоодын хяналт тавина.

2.19. Ажилтныг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаартай "Худалдаа үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам"-д заасны дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан байна.

2.20. Үйлчлүүлэгч болон ажилтны ариун цэврийн өрөөнд гар угаах нөхцөлийг бүрдүүлж, гар угаах шингэн саван, гар халдваргүйжүүлэх уусмалыг хүрэлцэхүйц хэмжээгээр байршуулна.

2.21. Өдөр бүр цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шатны бариул, лифтний товчлуур, хаалганы бариул, унтраалга, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн гадаргуу, гишгүүр, сандал, хувцасны шүүгээ, бариул гэх мэт хүний гар хүрэх эд зүйлсийн гадаргууг 2 цаг тутамд халдваргүйжүүлэх уусмалаар шүршиж арчин халдваргүйжүүлж, хяналт тавьж ажиллана.

2.22. Цэвэрлэгээнд хэрэглэсэн алчуур, хувин багаж, хэрэгслийг цэвэрлэж, халдваргүйжүүлсний дараа цэвэр усаар сайтар зайлж хатааж хадгална.

2.23. Өдөрт 1 цаг тутамд 15 минутын турш энгийн салхивчийг нээж агаар сэлгэлт хийх механик агааржуулалтын системийг тогтмол ажиллуулна.

2.24. Өөрийн эзэмшсэн болон орчны 50 метр хүртэлх талбайд хог хаягдлыг тогтмол цэвэрлэж зайлуулна.

2.25. Амны хаалтгүй хүнд үйлчлэхгүйгээс гадна амны хаалт, гар халдваргүйжүүлэгч худалдан авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.26. Багш, ажилчид, хүүхдийг хүлээн авахдаа биеийн халуун, амьсгалын замын халдварын ямар нэгэн шинж тэмдэг (толгой өвдөх, ханиалгах, хамраас нус гоожих гэх мэт) илэрч буй эсэхэд үзлэг хийж, хүлээн авна.

2.27. Биеийн халууны хэмжилтээр $37,1^{\circ}\text{C}$ -ээс дээш, энэхүү зөвлөмжийн 2.26-д заасан эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн ажилтны багш, ажилтан, хүүхдийн овог нэр, регистийн дугаар, оршин суух хаяг, утасны дугаар зэрэг мэдээллийг авч, харьяа өрх, сумын эрүүл мэндийн байгууллагад хандахыг зөвлөнө.

2.28. Амрахаар ирсэн хүн бүрийн овог нэр, регистр, гэрийн хаяг, утасны дугаарыг авч бүртгэл хөтөлнө.

2.29. Хүүхдийг олноор нь нэг дор цуглуулах арга хэмжээг зохион байгуулахгүй байна.

2.30. Багш, ажилтан, амрагч хүүхдийг тогтмол амны хаалт зүүлгэн, биеийн халууныг өдөрт 2-оос доошгүй удаа үзэж, тэмдэглэл хөтлөн, тандалт хийж ажиллана.

2.31. Амрах байранд орох, гарах хөдөлгөөн, гадны хүн нэвтрүүлэхгүй байхад хяналт тавьж ажиллана.

2.32. Нүхэн жорлонтой тохиолдолд долоо хоногт 2-3 удаа халдваргүйжүүлэлт хийнэ.

2.33. Багш, ажилчид, суралцагчдад халдвараас урьдчилан сэргийлэх ялангуяа амны хаалтыг тогтмол зөв зүүж, хэрэглэсэн амны хаалтыг тагтай хогийн саванд хаях, ил задгай хаяхгүй байх, гараа тогтмол савандаж угаах, хоорондоо 1-1,5 м зайнаас харьцах, ханиах, найтаахдаа ам, хамраа дарах, олон хүн цугларсан газраар явахгүй байх зэрэг зөвлөгөө, мэдээллээр тогтмол хангаж ажиллана.

2.34. Багш, ажилчид, хүүхдэд толгой өвдөх, халуурах, ханиалгах, хоолой өвдөх, гүйлгэх, хамар битүүрэх, ядрах, булчин өвдөх зэрэг шинж тэмдэг илэрсэн тохиолдолд түр тусгаарлаж, харьяалах эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдээлж, тэдний зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.35. Зааланд бэлэн хоол, амархан муудах хүнсний бүтээгдэхүүн худалдаалахгүй, гаднаас хоол хүнсний зүйл оруулахыг хориглоно.

Гурав. Тусгай шаардлага

3.1. Хүүхдийн зуслангууд дээд тал нь 40 хүлээн авах байр танхимыг бэлтгэнэ. Нэг байранд нэг гэр бүлийг байрлуулах бөгөөд 4-5 хүн байна.

3.2. Нийтийн хоолны газарт иргэдэд үйлчилгээ үзүүлэхийг хориглоно. Хоолыг өрөөнд зөөвөрлөх, хүргэх үйлчилгээ үзүүлнэ.

3.3. 5-аас дээшгүй хүнд хөгжлийн хөтөлбөрийн үйлчилгээ үзүүлнэ.

3.6. Хүүхдийн зуслангийн орчны цэвэрлэгээг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын зургаадугаар хавсралтын дагуу хийнэ.

3.7. Тусгаарлах, ажиглах байранд иргэн хурц үзүүртэй мөс, архи, согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх, халуун бууруулах, өвчин намдаах, эм, бодис, түргэн гэмтэж, муудах хүнсний бүтээгдэхүүн авч оруулахыг хориглоно.

Дөрөв. Хөтөлбөр үйл ажиллагаа

4.1. Зусланд хэрэгжүүлэх гэр бүлийн тусгай хөтөлбөрийг аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (хэлтэс)-ээр батлуулна.

4.2. Хөгжлийн хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа нэг удаад 40-60 минут байна.

4.3. Хөтөлбөр үйл ажиллагааг дотор нь

1. Гэр бүлийн хөтөлбөр
2. Эцэг, эхчүүдэд чиглэсэн хөтөлбөр
3. Хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр гэж ангилан явуулна.

4.4. Гэр бүлийн хөтөлбөр нь эцэг, эх, хүүхдүүдийг хамарсан гэр бүлийн тусгай хөтөлбөр байна.

4.5. Хүүхдэд чиглэсэн хөтөлбөрийн хувьд хүүхдийн гэр бүл дэх оролцоог нэмэгдүүлэх, хүмүүжил төлөвшилд чиглэсэн хөтөлбөр байна.

4.6. Эцэг, эхийн хөтөлбөрийн хувьд хүүхдийг ойлгох, тусалж дэмжихэд чиглэхээс гадна гэр бүлийн тогтвортой байдлыг бий болгоход чиглэнэ.

4.7. Хөгжлийн хөтөлбөрийг танхимын оролцооны хэлбэрээр зохион байгуулах ба эрүүл ахуй, ариун цэврийн дэглэм, шаардлагыг мөрдөж ажиллана.

4.8. Ой модонд аялах, голын усанд сэлэх, мал, амьтантай харьцах зэрэг үйл ажиллагаа төлөвлөхийг хориглоно.

4.9. Нийтийг хамарсан зуслангийн нээлт, хаалтын арга хэмжээ, бүжиг, диско, тэмцээн, уралдаан зэргийг зохион байгуулахыг хорилоно.

4.10. Сургалтын анги, танхим, хэрэглэгдэхүүнийг тухай бүр мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу халдваргүйжүүлнэ.

Тав. Тээвэр үйлчилгээ

5.1. Зуслан нь өөрийн тээврийн хэрэгслээр амрагчдад үйлчилнэ.

5.2. Амрагчдын хувийн тээврийн хэрэгсэл болон нийтийн тээврийг зусланд ирэх очиход ашиглахгүй.

5.3. Амрагчдыг тээвэрлэх тээврийн хэрэгсэлд өмнө, дараа тогтмол халдваргүйжүүлэлт хийх ба халдваргүйжүүлэлт хийх багаж хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, гар халдваргүйжүүлэх бодис зэргийн нөөцийг бүрдүүлж байршуулна.

5.4. Жолооч болон амрагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, санамж, зөвлөмжийг байршуулсан байна.

Зургаа. Амрагчдаас хүлээх үүрэг

6.1. Тухайн байгууллагаас гаргасан журам, хуваарийг мөрдөх, иргэний үнэмлэх, гадаадын иргэн бол паспортоо биедээ байнга авч явах бөгөөд үйлчилгээний ажилтанд хувийн мэдээллийг үнэн зөв, гүйцэт өгнө.

6.2. Амрагчид нь амны хаалт тогтмол хэрэглэх, биеийн халууныг хэмжүүлж, халуунтай бол зуслангийн эмч болон эрүүл мэндийн байгууллагад хандан зөвлөгөө авна.

6.3. Амрагч бусадтай гар барихгүй байх, ханиаж найтаах тохиолдолд нугалсан тохойгоор болон алчуур, салфеткаар ам хамрыг бүрэн таглах, хэрэглэсэн алчуур, салфеткыг хогийн саванд хаяна.

6.4. Гарыг бохирдсон тухай бүр савандаж угаах, спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлнэ.

6.5. Ил задгай хог хаягдлыг өрөө тасалгаа, зуслангийн орчинд хаяхгүй байх.

6.6. Амрагчид гар утсандаа Эрүүл мэндийн яамнаас гаргасан "Шуурхай 119" аппликейшныг суулгасан байна.

Долоо. Хяналт тавьж хариуцлага тооцох

7.1. Зуслангийн үйл ажиллагаа эхлүүлэхэд мэргэжлийн байгууллагуудын ажлын хэсэг хяналт тавьж дүгнэлт гаргана. Үйл ажиллагааны явцад Аймаг, нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс (газар) нь хяналт тавьж, арга зүй зөвлөмж өгч ажиллана.

7.2. Журмын хэрэгжилтэд орон нутгийн засаг захиргаа, зөвшөөрөл олгосон болон хууль, хяналтын байгууллага хяналт тавьж, зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг шууд зогсоох, эрх бүхий байгууллагаар зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг авна.

7.3. Зуслангийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, ажилтан нь түр журмыг зөрчсөн, мэдээллийг үнэн бодитой мэдээллээгүй, зөрчлийг нуун дарагдуулсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу харицлага тооцож, арга хэмээ авна.

---oOo---